

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2019 оны 12 дугаар сарын 19-ны өдөр

Багануур дүүрэг

№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	2019 онд хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БҮРДСЭН ХОТ							
Эдийн засаг, төсөв санхүүгийн чиглэлээр:							
1	1.10. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	<p>1.10.1. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн үндсэн үйл ажиллагааг эхлүүлнэ.</p> <p>БХБЯ-ны 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн №2018/10 тоот гэрээгээр Мон-Энержи Консалт ХХК Паркийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгэж 2018 оны 09 дүгээр сарын 27-нд дуусах байсан боловч хугацааг 2 удаа сунгаж хойшлуулсан.</p> <ul style="list-style-type: none"> ➢ Паркийн ерөнхий төлөвлөгөөг НИТХ-аар хэлэлцүүлж батлуулсан ➢ Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгогдоогүй ч бусад гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулагдаж БХТ-ийн магадлангаар хянагдаж байна. ➢ Зураг төслийн ажил удааширсан нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгогдохгүй байгаагаас болж байна. Шалтгаан нь: <ul style="list-style-type: none"> ○ Эрчим хүчний сайдын 2018 оны 133 дугаар тушаалаар цахилгаан, дулааны техникийн нөхцөл олгохыг 2018 оны 09 дүгээр сарын 25-наас эхлэн 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл түр зогсоох шийдвэр гаргасан. 	БҮТП ОНӨТҮГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	90%	

- ЭХЯ-ны холбогдох газар нь, БҮТП-ийн ТЭЗҮ-ийг гүйцэтгэгч байгууллага ЭХЯ-ны **Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар** хэлэлцүүлээгүй гэсэн шалтгаанаар хойшлуулсан.
- Мөн горимын ачааллын тооцоог Диспетчерийн үндэсний төв /ДҮТ/-өөр заавал гүйцэтгүүлэх шаардлагатай гэсэн шаардлагыг төсөл гүйцэтгэгч компанид тавьсан.

- Паркийн захиргаа уг асуудлыг Эрчим хүчний сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарт танилцуулснаар цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг олгох асуудлыг 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр **Эрчим хүчний хэрэгжилтийн Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгох ажлын хэсгийн хурлаар** БХБЯ, БХТ, Мон-Энержи Консалт ХХК, НШУҮИГ, БҮТП-ийн дарга болон холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан хэлэлцэж шийдвэрлэсэн.
- Одоо ДҮТ нь төслийн горимын ачааллын тооцоог гаргаж, Мон Энержи ХХК нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн дагуу зураг төслийг боловсруулан дуусгаж байна.


Дэд бүтцийн бүтээн байгуулалтын санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулав:

- Дээд шатны 6 байгууллагад санхүүжилтийн асуудлыг тавьж санал хүргүүлсэн.
- МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголд паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын 161,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2019-2021 онуудад тусгуулахаар ҮХГ-т хүргүүлсэн.
- Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг боловсруулж НШУҮИГ, БХБЯ, УУХҮЯ-дад тус тус хүргүүлсэн.
- Багануур дүүргийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг тусгуулахаар саналыг хүргүүлсэн.
- МУ-ын дунд болон урт хугацааны зорилтот хөтөлбөр болох Шинэ бүтээн байгуулалтын хөтөлбөрт дэд бүтцийн бүтээн байгуулалтын саналыг хүргүүлэв.
- Паркийн зүгээс БХБЯ-нд 2019 оны 06 сард хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн дэд бүтэц, дэд станцын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын саналыг боловсруулж хүргүүлэв.

		<ul style="list-style-type: none"> - Багануур дүүргээс сонгогдсон УИХ-ын 4 гишүүнд, 2020 онд эхлүүлэх паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг танилцуулж дэмжлэг хүссэн албан бичиг хүргүүлсэн. - Нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг боловсруулж байгаатай холбогдуулан зохих журмын дагуу дэд бүтцийн бүтээн байгуулалтын тооцоолол зураглалыг боловсруулж тус тус хүргүүлсэн. - Хүнд үйлдвэрлэлийн бүсийн 20,1 тэрбум төгрөгийн санхүүжилттэй дэд бүтцийн бүтээн байгуулалтын зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх үүднээс Багануур ХК-ийн одоогоор ашиглалтгүй байгаа ("Породная станция") төмөр замын хөрс тээвэрлэлтийн станцын барилга байгууламж, дэд бүтцийг ашиглах боломж байгааг судалж, саналаа 2020 оны 1-р улиралд Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахаар төлөвлөж байна. ➤ Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журмын 3.4 /Паркийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн дагуу эрдэм шинжилгээ судалгаа явуулах нэгж, технологийн инкубатор төв байгуулах заалтын дагуу ХААИС, Ургамал хамгааллын эрдэм, шинжилгээний хүрээлэн, ШУТИС, ШАУИС-иудтай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулж дунд хугацааны төлөвлөгөөтэй ажиллаж байна. ➤ 2019 оны 03 дугаар сарын 22, 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрүүдэд БҮТП-д Биотехнологийг хөгжүүлэх нь уриан дор "Ховор эмийн ургамал, жимс жимсгэнэ тариалах нь" сэдэвт IV, V уулзалт зөвлөгөөнийг дүүргийн үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан амжилттай зохион байгуулж, Хөх нуурын био станц, Хэрлэн баян-Улааны ховор эмийн ургамлын плантацитай танилцаж туршлага судлав. Тус арга хэмжээнд ХААИС, ШАУИС, УХЭШХ болон ШУҮ-ийн Монхимо ХХК-иудын төлөөллүүд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын илтгэл тавьж оролцсон. ➤ Паркад үйлдвэр байгуулах хүсэлтэй дараах байгууллагуудын мэдээллийг хүлээн авч паркийн эрх зүйн байдал, эзэмшил газар, дэд бүтцийн нөхцөлийн талаар санал солилцож, зөвлөгөө өгөв. Үүнд: - "Синкопа Монгол" ХХК-ны Нүүрсний химийн үйлдвэрийг байгуулах санал 		
--	--	--	--	--

		<ul style="list-style-type: none"> - “Очир Ундраа” ХХК-ны Багануурын уурхайн нүүрсээр тэсэлгээний бодис үйлдвэрлэх санал - “Хемп Монгол” ХХК-ны Эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал - Казахстан улсын “Эрдэс баялгийг иж бүрэн боловсруулах үндэсний төв” болон “Эко импаст” ХХК-ийн удирдлагаас Багануурын уурхайн нүүрс, шорооны хаягдлаас цахиурт хөнгөнцагааны хольц үйлдвэрлэх төсөл хэрэгжүүлэх боломж байгаа талаар дүүргийн болон паркийн удирдлагад танилцуулав. Дараа нь уурхайн үйл ажиллагаатай танилцуулж, нүүрсний үнсний шинж чанарын мэдээлэл болон судалгааны зориулалтаар нүүрс шорооны холимгийн дээжийг авах ажлыг зохион байгуулав. Мөн “Монгол Минерал” ХХК, түүний түнш Герман улсын “PHARMAWERK” компанийн удирдлагуудад паркийн үйл ажиллагааг танилцуулан исэлдсэн нүүрсний гуминыг хүн болон мал эмнэлгийн эмчилгээнд ашиглах чиглэл, түүний нөөцийн асуудлаар санал солилцож Багануурын нүүрсний уурхай үйл ажиллагааг танилцуулав. - 2019 онд Нийслэлийн Засаг даргын А/619 дүгээр захирамжаар паркад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх 30 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр нарийвчилсан үнэлгээг “Санни трейд” ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд ондоо багтаан дуусгах гэрээтэй ажиллаж байна. 			
ГУРАВ. БАЯЛАГ БҮТЭЭГЧДЭЭ ДЭМЖСЭН, ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖСӨН ХОТ					
2	<p>3.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд nano технологи, аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, томоохон болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.</p>	<p>3.1.1. “Адуу” брэндийн бүтээгдэхүүнийг экспортод гаргах ажлыг бодлогоор дэмжинэ.</p>	<p>БҮТП ОНӨТҮГ Монхимо ХХК</p>	<p>Үйл ажиллагаан ы хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>
		<ul style="list-style-type: none"> - Паркийн нэгж Монхимо ХХК нь Оросын Холбооны Улсад бүтээгдэхүүн экспортлох албан ёсны зөвшөөрлүүдийг авч үйлдвэрлэлийн өргөтгөлийн - ажилд бэлтгэж байна. Өөрийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж дотоодын хэрэгцээнд нийлүүлэн ажиллаж байна. - Ерөнхий сайд болон салбарын сайдуудыг Багануур дүүрэгт ажиллах хугацаанд паркийн зүгээс “Адуу” брэндийн үйлдвэрлэлийн өргөтгөлд шаардлагатай 5,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх асуудлыг танилцуулсан. - Мишээл экспод 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан Уул уурхай - 2019 үзэсгэлэн болон 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн УУХҮЯ-ны өдөрлөгөөр Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нийт 350 гаруй хүнд танилцуулсан. 	<p>75%</p>		

		<ul style="list-style-type: none"> - Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр Засгийн газраар батлагдсан боловч, Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй гэх шалтгаанаар ХХААХҮЯ болон Сангийн Яамнаас олгоогүй. - Паркийн зүгээс Ерөнхий сайд болон салбарын сайдуудыг Багануур дүүрэгт ажиллах хугацаанд Гэрийн тэжээмэл амьтны тэжээлийн үйлдвэр нь малын дайвар ашиглан жилд 10 тонн бүтээгдэхүүн экспортод гаргаж, 30 ажлын байрыг бий болгох бөгөөд нийт 300,0 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг танилцуулсан. 						
	3.10. Гадаадын хөрөнгө оруулалттай, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий ноос гүн боловсруулах эко үйлдвэрийн ажлыг дэмжиж эхлүүлнэ.	3.10.1. Ноос, ноолуур гүн үйл боловсруулах үйлдвэрийн ажиллагааг дэмжинэ.	БҮТП ОНӨТҮГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%			
3		Паркийн зүгээс төслийг дэмжин бүхий л арга хэмжээг авч ажилласан. Тухайлбал: Төслийн ТЭЗҮ-д шаардлагатай байгаль орчин, газар зохион байгуулалт, нийгэм эдийн засаг, зах зээлийн бүх талын судалгаа мэдээллийг хүргүүлсэн. Цаашид паркийн дэд бүтцийг бүтээн байгуулсны дараа хөнгөн үйлдвэрлэлийн бүсэд дэвшилтэд технологийн ноос, ноолуур гүн боловсруулах эко үйлдвэрүүдийн төслийг сонгон шалгаруулалтаар авч эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.					100%	



ТАЙЛАН ХЯНАСАН:
 БАГАНУУР ҮЙЛДЭРЛЭЛТ ТЕХНОЛОГИЙН ПАРК
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА *[Signature]* Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Б.МИЧИД-ЭРДЭНЭ